

1-р сарын цаг үеийн мэдээ

Төр захиргааны чиглээр:

2021 оны 1 сарын байдлаар иргэдээс Засаг дарга болон Тамгын газрын дарга, холбогдох албан тушаалтнуудад хандаж 1 өргөдөл гомдол ирүүлж, шийдвэрлэх хугацаа болоогүй байна.

Цэргийн бэлтгэл үүрэгтний судалгааг цэргийн хэлтсийн цахим хаягаар хүргүүлсэн.

Зэрэг дэв олгуулах материалыг хүргүүлсэн.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Улс, аймгийн сайн малчины материалыг бэлтгэж хүргүүлсэн.

Сум хөгжүүлэх сангаас зээл авч эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн зээлдэгч нарт мэдэгдэх хуудас өгч ажиллалаа.

ААН, албан байгууллагуудад QR кодыг ашиглах заавар өгч ажилласан.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөц, хүнсэнд хэрэглэсэн малын тоо, зах зээлд борлуулсан малын тоо, сүүний нөөцийг зэргийг судалгааг гаргасан.

Улаанбаатар хотруу мах, махан бүтээгдэхүүн тээвэрлэж байгаа 7 машинд QR кодыг олгосон.

Сумын хэмжээнд ийт 207 ширхэг арьс ширний урамшууллын падан шивэгдсэн.

Санхүүгийн чиглэлээр:

2021 төсвийн хуваарийг хянаж сумын Засаг даргаар батлуулан аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

2020 оны гүйцэтгэлийн мэдээг хянаж баталгаажуулсан.

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын мэдэгдлийн дагуу орон нутгийн төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарт баримт материалыг бүрэн жагсаалтын дагуу бүрэн гүйцэт хүргүүлэх талаар зөвөлгөө өгч ажилласан.

2020 оны санхүү тайланг 2021.01.18-28 хооронд төсөвт байгууллагууд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт хуваарийн дагуу шалгуулж байна.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

Иргэний бүртгэлийн үйлчилгээг иргэний хүсэлтийн дагуу тасралтгүй хүргэж ажиллаж байна.

- ☐ Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл Үүнд :
- ☐ Төрсний бүртгэл – 3
- ☐ Гэрлэлтийн бүртгэл - 2
- ☐ Нас барсны бүртгэл – 2
- ☐ Иргэний цахим үнэмлэх олголт:
- ☐ Иргэний үнэмлэх захиалга ИУБ-31 – 6 иргэн
- ☐ Иргэний үнэмлэх олголтын бүртгэл - 1 иргэн
- ☐ Иргэний үнэмлэхний лавлагаа олголт албан хэрэгцээнд – 12
- ☐ Иргэний үнэмлэхний лавлагаа олголт иргэнд – 1
- ☐ Иргэний шилжилт хөдөлгөөн

- ☐ Аймаг нийслэл хооронд шилжин ирсэн – 1 иргэн
- ☐ Сум хооронд шилжин ирсэн – 1 иргэн
- ☐ Лавлагаа гэрчилгээ дахин олголт
- ☐ Гэрлэлт бүртгэлийн лавлагаа -2 иргэнд
- ☐ Төрсөний бүртгэлийн лавлагаа – 3 иргэнд
- ☐ Гэрлэлт бүртгэлгүй лавлагаа албанд – 2 иргэний бүртгэлийг холбогдох

бичиг баримтыг хүлээн авч хүсэлтийн дагуу шийдвэрлэж ажиллалаа.

Байгаль орчны чиглэлээр:

Цасны хэмжилт хийхэд 2-р багийн нутаг Ноён хөндийд 10-15 см, Цөнгөрөг, Тайгын хөндий зэрэг цэгүүдэд 9-10 см зузаан цастай байна.

Хог хаяхгүй байх, байгаль орчноо хайрлан хамгаалах тухай мэдээллийг иргэдэд цахим орчинд уриалж ажилласан.

Нийт золбин 8 нохойд хор өгч устгасан.

Нийгмийн халамжийн чиглэрээр:

Зорилтот өрхүүдэд 2021 онд хийх ажлын төлөвлөгөө гарган сумын иргэдийн төлөөлөгчийн хурлаар төсвийг батлуулсан.

Үйлчилгээ авч байгаа иргэдээ нас,хүйс,боловсрол,үйлчилгээ авсан төрлөөр нь дэлгэрэнгүй бүртгэл хөтлөн ажиллаж байна. Үүний дагуу 1 сарын 21-ны байдлаар 15 иргэнд 6 чиглэлээр мэдээлэл өгч ажилласан байна.

Боловсрол, соёлын чиглэлээр:

Багийн засаг дарга нартай хамтран цэцэрлэгийн насны “Алслагдсан хүүхдийн судалгаа”-г гаргаж, 113 хүүхдийн эцэг эхтэй холбогдон томуу томуу төст өвчинтэй эсэх талаарх мэдээллийг лавласан. Судалгаагаар сумын төвд 78, хөдөө 32, бусад аймаг хотод 3 хүүхэд тус тус байна.

Цахимаар “ГЭР БҮЛИЙН ОРЧИНД ХӨГЖИЖ БУЙ ХҮҮХЭД” сэдвээр хүүхдийн бүтээлийг байршуулах ажил явагдаж байна.

UBT.mn шалгалтын системд багш нар мэргэжлийн хичээлийн чиглэл тус бүрээр шалгалтын сэдэв үүсгэж цахимаар сурагчдаа ажиллуулж байна.

Отроор болон өвөлжилт хүндэрсэн алслагдсан өрхөд амьдарч буй өрхийн сургуулийн насны хүүхдийн судалгааг баг бүрээр гаргаж, сургуулийн захиргаа болон аймгийн БСУГазарт танилцуулж ажилласан.

Сургуулийн хүүхэд хамгааллын багийн гишүүд анги удирдсан багш нартай хамтран хүүхдийн нөхцөл байдлын болон эрсдлийн үнэлгээг 4 сурагчдад хийж хамтран гэрийн эргэлтээр хийж ажилласан.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үндсэн үзүүлэлтүүд:

- Нийт үзлэг-237
- ☐ Амбулаторийн үзлэг-30
- ☐ Гэрийн идэвхитэй хяналт-22
- ☐ Урьдчилан сэргийлэх-68
- ☐ Артерийн гипертензин эрт илрүүлэг-40
- ☐ Чихрийн шижин эрт илрүүлэг-40

- Жирэмсний хяналтанд хамрагдсан-2
- Жинэлсэн хүүхдийн тоо-15
- Эмнэлэгт хэвтсэн-15
- Холын дуудлага-19
- Төвийн дуудлага-52

“Хэвтэн эмчлүүлсэн эмчилгээний хоол”-ны сургалтыг хэвтэн эмчлүүлсэн 5 иргэнд зохион байгуулсан.

Ковид-19 өвчний үед хоололтын зөвлөмжийн талаар видео-1, шторк-1, “Голомттой бүсээс ирж байгаа иргэдэд өгөх зөвлөмжийг тус тус цахим хаягт байршуулахад хандалт 100 гаруй байна.